

Лабораторийн эмч, нян судлаач эмч, лаборантийн зэргийн шалгалтанд орохын тулд дараах тусгай шалгуурыг хангах бөгөөд үүний баталгааг бүрдүүлэх материалд тусгаж, шаардлагатай нотлох баримтыг ирүүлнэ.

1. ЛАБОРАНТИЙН АХЛАХ ЗЭРЭГ:

- Эмнэлгийн захиргаа, хүний нөөцийн албанаас ажил байдлын тодорхойлолт ирүүлнэ. Тодорхойлолтонд дараах чадварыг заавал үнэлсэн байна.
 1. Мэргэжлээрээ эмнэлгийн лабораторт 8-аас доошгүй жил ажилласан
 2. Ахлах зэргийн лаборантын үүрэг гүйцэтгэх, багаар ажиллах чадвар
 3. Эмнэлгийн ажилтны ёс суртахууны доголдол гаргаагүй байх
 4. Хамт олны хурлаар 100 хувь зөвшөөрсөн санал авсан байх
 5. Шинэ ажилтныг (1-2) дагалдуулан мэрэгжилд нь гаршуулсан тухай
 6. Лабораторийн бүх хэсэг дээр тойрч ажилласан тухай
- ОПБХ -д мэрэгжлийн чиглэлээр 2 илтгэл тавьж хэлэлцүүлсэн (хамтарсан байж болно, баталгааг эх хувиар нь ирүүлнэ)
- Ажлын байран дээрхи сургалтанд 3-аас доошгүй сэдвээр хичээл заасан байх (байгууллагаас хичээл заасныг баталсан байх)
- Мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй
- Шинэ бүтээл, оновчтой санал, тэргүүн туршлагын бүтээлтэй байх (гэрчилгээ, баримтаар баталгаажуулна)

2. ЛАБОРАНТИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗЭРЭГ:

- Эмнэлгийн захиргаа, хүний нөөцийн албанаас ажил байдлын тодорхойлолт ирүүлнэ. Тодорхойлолтонд дараах чадварыг заавал үнэлсэн байна.
 1. Ахлах зэрэгтэйгээр 5 жил ажилласны баталгаа, жил жилийн үнэлгээ
 2. Тэргүүлэх зэргийн лаборантын үүрэг гүйцэтгэх, багаар ажиллах чадвар
 3. Эмнэлгийн ажилтны ёс суртахууны доголдол гаргаагүй байх
 4. Хамт олны хурлаар 100 хувь зөвшөөрсөн санал авсан байх
 5. Шинэ ажилтаныг (2-5) дагалдуулан мэрэгжилд нь гаршуулсан тухай
- Лабораторийн шинэ технологи, тэргүүн туршлага эзэмшсэн байх
- Ахлах зэрэг хамгаалснаас хойш ОПБХ –д 2 илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх (хамтарсан байж болно, баталгааг эх хувиар нь ирүүлнэ)
- Ажлын байран дээрхи сургалтанд 5-аас доошгүй сэдвээр хичээл заасан байх (байгууллагаас хичээл заасныг баталсан байх)
- Шинэ бүтээл, оновчтой санал, тэргүүн туршлагын бүтээлтэй байх (гэрчилгээ, баримтаар баталгаажуулна)

3. ЛАБОРАТОРИЙН БОЛОН НЯН СУДЛААЧ ЭМЧИЙН АХЛАХ ЗЭРЭГ:

- Эмнэлгийн захиргаа, хүний нөөцийн албанаас ажил байдлын тодорхойлолт ирүүлнэ. Тодорхойлолтонд дараах чадварыг заавал үнэлсэн байна.
 1. Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласны баталгаа, ажлын жил жилийн үнэлгээ
 2. Эмнэлгийн ажилтны ёс суртахууны доголдол гаргаагүй байх
 3. Хамт олны хурлаар 100 хувь зөвшөөрсөн санал авсан байх
 4. Гадаад хэлний болон компьютерийн зохих түвшин хангасан (сертификатаар баталгаажуулна)
- Мэргэжил олгох курс, резидентийн сургалтанд хамрагдсан байх
- ОПБХ -д 5-аас доошгүй илтгэл тавьж хэлэлцүүлсэн байх (хамтарсан байж болно, баталгааг эх хувиар нь ирүүлнэ)
- Мэргэжлийн хэвлэлд 2 бүтээл нийтлүүлсэн (хамтарсан байж болно, баталгааг эх хувиар нь ирүүлнэ)
- Ажлын байрны сургалтын гарын авлага, арга зүйн зөвлөмж боловсруулсан (хамтарсан байж болно, баталгааг эх хувиар нь ирүүлнэ)
- Мэргэжлийн чиглэлээр шинэ бүтээл, оновчтой санал, тэргүүн туршлагын бүтээлтэй (гэрчилгээ, баримтаар баталгаажуулна)
- Байгууллага, салбараа хөгжүүлэх төсөл хэрэгжүүлсэн эсвэл боловсруулсан байх (боловсруулсан эсвэл хэрэгжүүлсэн төслийн талаар байгууллагаас тодорхойлолттой байх)
- Мэргэжлийн чиглэл, эмнэлзүйн тайлалаар лабораторийн болон үзлэгийн эмч нарт 5-аас доошгүй сэдвээр сургалт явуулсан байх (байгууллагаас хичээл заасныг баталсан байх)

4. ЛАБОРАТОРИЙН БОЛОН НЯН СУДЛААЧ ЭМЧИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗЭРЭГ:

- Эмнэлгийн захиргаа, хүний нөөцийн албанаас ажил байдлын тодорхойлолт ирүүлнэ. Тодорхойлолтонд дараах чадварыг заавал үнэлсэн байна.
 1. Ахлах зэрэг хамгаалаад 5-аас доошгүй жил ажилласны баталгаа, ажлын жил жилийн үнэлгээ
 2. Лабораторийн эрхлэгчээр ажиллах, багаар ажиллах чадвар
 3. Эмнэлгийн ажилтны ёс суртахууны доголдол гаргаагүй байх
 4. Хамт олны хурлаар 100 хувь зөвшөөрсөн санал авсан байх
 5. Гадаад хэлний болон компьютерийн зохих түвшин хангасан (сертификатаар баталгаажуулна)
- Ахлах зэрэг хамгаалснаас хойш хэвлэн нийтлүүлсэн, эрдэм судалгааны ажил хийсэн бүтээлийн жагсаалт ирүүлэх (хамтарсан байж болно, баталгааг эх хувиар нь ирүүлнэ)

- Чанарын менежментийн тогтолцоог байгууллага дээрээ нэвтрүүлсэн байх
- Ажлын байран дахь сургалт 8-аас доошгүй сэдвээр явуулсан байх (байгууллагаас хичээл заасныг баталсан байх)
- Байгууллага салбараа хөгжүүлэх талаар төсөл хэрэгжүүлсэн эсвэл боловсруулж үр дүнгийн тооцоо хийсэн байх (боловсруулсан эсвэл хэрэгжүүлсэн төслийн талаар байгууллагаас тодорхойлолттой байх)
- Мэргэжлийн чиглэл, эмнэлзүйн тайлалаар лабораторийн болон үзлэгийн эмч нарт 8-аас доошгүй сэдвээр сургалт явуулсан байх (байгууллагаас хичээл заасныг баталсан байх)

5. ЛАБОРАТОРИЙН ЗӨВЛӨХ ЭМЧИЙН ЗЭРЭГ:

- Эмнэлгийн захиргаа, хүний нөөцийн албанаас ажил байдлын тодорхойлолт ирүүлнэ.
- Эрүүл мэндийн салбарт мэргэжлээрээ тасралтгүй 20-иос дээш жил ажилласан байх
- Лабораторийн болон нян судлалын мэргэжлээр ахлах, тэргүүлэх зэргийг дараалан хамгаалсан байх
- Мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээ судлалгааны ажилд тогтмол оролцдог байх
- Мэргэжлийн чиглэлээр хэвлэн нийтлүүлсэн бүтээлийн жагсаалтаа ирүүлэх
- Мэргэжлийн чиглэлээр эмч, оюутны сургалтын үйл ажиллагаанд оролцдог бөгөөд гарын шавь нар бэлтгэсэн байх
- Мэргэжлийн чиглэлээр боловсруулж нэвтрүүлсэн арга зүй, зааварчилгаа, стандарт, шинэ бүтээл, оновчтой саналын жагсаалт ирүүлэх
- Сүүлийн 5 жилийн ажлын дэлгэрэнгүй тайлан ирүүлэх
- Эмнэлгийн ажилтны ёс суртахууны доголдол гаргаагүй байх
- Байгууллага, салбараа хөгжүүлэх төсөл боловсруулсан, хэрэгжүүлсэн байх (хэрэгжүүлсэн төслийн талаар байгууллагаас тодорхойлолттой байх)
- Чанарын менежментийн тогтолцоог байгууллага дээрээ нэвтрүүлсэн байдал
- Мэргэжлийн шалгалтанд орох, эсэхийг магадлах шалгуур үзүүлэлтүүд:
 1. Мэргэжлийн тэргүүлэх зэргийг дараалан (давтан) 2-оос доошгүй удаа хамгаалсан/клиникийн профессор/АУ-ны магистр цолтой лабораторийн салбарт 20-оос дээш жил ажилласан эмч нар дээрх шалгуурын дагуу тайлан хамгаалах журмаар зөвлөх зэргийг хамгаална. Ярилцлагын асуулт тухайн үед нэмэлтээр тавигдана.
 2. Мэргэжлийн тэргүүлэх зэргийг хамгаалаад 5 жил болсон, 20-оос дээш жил мэргэжлээрээ ажилласан эмч, мэргэжлээр онолын шалгалтыг зохих журмын дагуу өгнө.